



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/47

Өмнөдэлгэр сум

**Тамхи худалдан борлуулах тусгай
зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр сумын 6 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг “Юмт гэгээ” ХХК (2162245)-д тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 2028 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахыг “Юмт гэгээ” ХХК-ийн захирал Ж.Ринад үүрэг болгосугай.

3.Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий иргэнд хяналт тавьж ажиллахыг татварын улсын байцаагч, Хөдөө аж ахуйн тасагт даалгасугай.



Р.ЭНХТӨР

የሰው ዓለት፣ ለ ለገሰ፣
 ለገሰ ለገሰ ለገሰ ለገሰ ለገሰ ለገሰ